



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/572

Эрдэнэт


Сургалтын зардал гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 а, 29.2, 33 дугаар зүйлийн 33.1.6, Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төрийн албан хаагчдын 2017 оны сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдах сумдын Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдыг чадавхижуулах "Төрийн албаны болон төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ" сургалтын зардал 5000000 /Таван сая/ төгрөгийг 2017 оны Засаг даргын нөөц сан, хуваарилагдаагүй бусад зардлын жагсаалтад тусгагдсан төрийн албан хаагчдыг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

2. Сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /н.Соёлчхүү/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ